



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 19 өдөр

Дугаар А/359

Мөрөн сум

Газар өмчлөх эрхийг дуусгавар болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Намсрай овогтой Нандинцэцэг /PP77071566/ -нь өөрийн хүсэлтээр газар өмчлөх эрхээсээ татгалзаж байгаа тул аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн А/85 дугаар захирамжийн хавсралтын 2 дугаар заалтыг хүчингүй болгож Монгол улсын иргэнд нэг удаа газар үнэгүй өмчлөх эрхийг дуусгавар болгосугай.

2. Газар өмчлөх эрхээсээ татгалзсан иргэний газрыг улсын бүртгэлээс хасахыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул)-т даалгасугай.

3. Аймгийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/03 дугаар захирамжийн хавсралтын 3 дугаар заалтын иргэн Н.Нандинцэцэг-д холбогдох хэсгийг хүчин төгөлдөр хэвээр үлдээсүгэй.

4. Аймгийн Засаг даргын энэхүү шийдвэрийг оролцогчид эс зөвшөөрвөл мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурьдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Д.Түмэнбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН